



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,  
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2024.07.25 № 1 / 2638

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Төсвийн санал хүргүүлэх тухай

Тус хороо нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, олон улсын жишигт нийцүүлэн хурдтай, үр дүнтэй хөгжүүлэх, зах зээлийн эрсдэлийг бууруулах, шинээр батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хяналт шалгалт, зохицуулалтын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх болон төсвийн үр ашгийг сайжруулахад анхаарч Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн саналыг боловсруулан хүргүүлж байна.

Тус Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлж, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай дараах зардлуудыг тусгасан болно. Үүнд:

1. Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу төрийн албан хаагчдын албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цол, зэрэг дэв, хоол, унааны хөнгөлөлт, бусад нэмэгдэл хөлс, үр дүнгийн урамшуулал, мөн тус Хорооны хяналт зохицуулалтад хамаарах салбарын үйл ажиллагаа хуулиар нэмэгдсэнтэй холбогдуулан шинээр нэмэгдэж байгаа орон тоонд хамаарах цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад нийгмийн баталгааг хангахад зориулах нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох зардал;

Мөн Засгийн газрын 2024 оны 121 дүгээр тогтоолоор төрийн албаны цалингийн хэмжээг нийтэд нь 10%-аар нэмэгдүүлсэн, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт орж төрийн жинхэнэ албан хаагчид олгох ажлын үр дүнгээр тооцох улирлын мөнгөн урамшууллын хэмжээнд өөрчлөлт орсон зэрэг зөрүүт тооцож төлөвлөлөө.

2. Засгийн газрын байранд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын эзэмшиж байгаа байр, талбай, авч байгаа үйлчилгээний хэмжээнд ногдох байр ашиглалтын зардлыг тухайн байгууллагын төсөвт суулган төлөвлөх, улсын төсвөөс санхүүжүүлж байхаар заасны дагуу тус зардлыг тусгасан ба байр ашиглалттай холбоотой метр квадратын зардал өмнөх оноос нэмэгдсэн тул тус зардлыг нэмэгдүүлсэн;

3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос дээш жил төлсөн, тэтгэвэр тогтоолгох нас хүрсэн, 2024 онд тэтгэвэрт гарах хүсэлтээ өгсөн 2 төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохтой холбоотой зардлыг журмын дагуу тооцож, тусгасан;

1518000711

4.Хорооны үндсэн үйл ажиллагаатай холбоотой эх үүсвэр дутагдаж байгаа эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулиудын шинэчилсэн найруулга, төслүүдийг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах, гадаад урсгал шилжүүлгийн зардал болох олон улсын гишүүн байгууллагын төлбөр хураамжийн гадаад валютын ханшийн зөрүү, “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, зохицуулалттай зах зээлийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын томилолтын зардлуудыг тус тус төсөвлөсөн.

5.Шинээр батлагдсан болон батлагдах хууль тогтоомж, дүрэм, журмыг 2024 онд хэрэгжүүлэхэд тус Хорооны Ажлын албаны бүтцэд шинээр 2 албыг байгуулах, мөнгөн зээлийн болон уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналтын чиглэлээр нийт 25 орон тоо нэмэгдүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага тулгарч байна. Үүнд:

а) Мөнгөн зээлийн зохицуулалтын алба (8) орон тоо.

Монгол Улсын Их Хурлаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээр Санхүүгийн зохицуулах хороо дээрх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус Хороо мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн бүртгэлийн асуудлыг хариуцах, бодлогоор хангаж, хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сан үүсгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж эхлээд байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус батлан, мөрдөж байна.

Иймд Мөнгөн зээлийн зохицуулалтын албыг дарга-1, бодлого зохицуулалтын чиглэлийн ахлах референт-1, референт-1, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн ахлах референт-1, референт-1, бодлого зохицуулалтын чиглэлийн ахлах мэргэжилтэн-1, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн мэргэжилтэн-2, нийт 8 орон тоотойгоор ажиллуулах шаардлагатай байна.

б) Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн алба (4) орон тоо.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Дээрх хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их хурал 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцан ажиллахаар заасан. Дээрх хуулийн хүрээнд “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам”, “Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага,

шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам”-ыг батлаад байна.

Иймд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн албыг дарга-1, бодлого зохицуулалтын чиглэлийн ахлах референт-1, референт-1, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн ахлах мэргэжилтэн-1, нийт 4 орон тоотойгоор ажиллуулах шаардлага бий болсон.

в) Хяналт шалгалт зохицуулалтын газарт мөнгөн зээлийн хяналтын чиглэлээр (5), уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналтын чиглэлээр (4) орон тоо.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хяналт шалгалтын чиг үүргийг ахлах референт-1, ахлах хянан шалгагч-1, хянан шалгагч-3, нийт 5 орон тоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналтын чиглэлийн ахлах хянан шалгагч-1, хянан шалгагч-3, нийт 4 орон тоотойгоор тус Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын бүтцэд ажиллуулах шаардлага бий болсон.

г) Санхүүгийн боловсрол, сургалтын алба (4) орон тоо.


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.13-д 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр нэмэлт орж “Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” чиг үүргийг хуулиар хүлээсэн. Санхүүгийн зах зээлийн салбарын өсөлт болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа, технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, сэндбоксын зохицуулалтын орчин, цаашлаад мөнгөн зээлийн үйл ажиллагаа буюу ломбард, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа зэрэг батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн боловсролыг олон нийт, хүүхэд залуучуудад хүргэх шаардлага тулгараад байна. Иймд Санхүүгийн боловсрол, сургалтын албанд ахлах референт-1, референт-1, ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн-1 нийт 4 орон тоогоор өргөжүүлэх шаардлагатай байна.

Иймд тус Хорооны 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, зорилт, салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах урсгал болон хөрөнгийн зардлын төсвийг дээрх шалтгаан, нөхцөлийг үндэслэн нэмэгдүүлж, төсвийн саналыг 23,193.0 сая төгрөгөөр батлуулах саналаа үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 8 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 1/26... тоот албан бичгийн хавсралт

ТӨСВИЙН САНАЛ БЭЛТГЭХ МАЯГТ ТМ-1

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ХӨТӨЛБӨР: Санхүүгийн зах зээл (70204)\*\*

Код	Гүйцэтгэл		Санал			Төсөвлөл		Өөрчлөлт		
	2023 Гүйц	2024 ХБГ	2024 бат	2025 ТЭЗ санал	2026 төсөвлөл	2027 төсөвлөл	2023		2025 хяз	2025 сан
							Гүйц	ХБГ		
<b>А. Зардлын эдийн засгийн зүйлс</b>										
2101	5,449,363.60	7,457,172.00	7,457,172.00	14,952,359.10	16,447,595.01	18,092,354.51	73%	100%	73%	50%
2102	692,725.20	932,147.00	932,147.00	1,885,597.70	2,074,157.47	2,281,573.22	74%	100%	74%	49%
2103	72,725.10	71,343.00	71,343.00	92,560.00	101,816.00	111,997.60	102%	100%	102%	77%
2104	31,265.20	24,742.00	24,742.00	37,113.00	40,824.30	44,906.73	126%	100%	126%	67%
2106	326.90	320.70	320.70	481.00	529.10	582.01	102%	100%	102%	67%
2107	54,965.80	35,556.00	35,556.00	271,321.00	298,453.10	328,298.41	155%	100%	155%	13%
2108	1,850,687.30	4,781,577.00	4,781,577.00	5,074,173.00	5,077,790.30	5,585,569.33	39%	100%	39%	94%
2109	1,260.00	1,237.00	1,237.00	2,350.00	2,585.00	2,843.50	102%	100%	102%	53%
212	-	-	-	-	-	-	-	-	-	-
213	374,438.00	531,042.00	531,042.00	627,064.00	689,770.40	758,747.44	71%	100%	71%	85%
22	435,996.00	892,500.00	892,500.00	250,000.00	275,000.00	302,500.00	49%	100%	49%	357%
Баруун үйлчилгээний бусад зардал										
<b>НИЙТ, Зардлын зүйлс*</b>										
8,963,753.10 14,727,636.70 14,727,636.70 23,193,018.80 25,008,520.68 27,509,372.75 61% 100% 61% 100% 64%										

Б. Зардлын зориулалт-арга хэмжээ

Код	Ундсын үйл ажиллагаа	2023 Гүйц	2024 ХБГ	2024 бат	2025 ТЭЗ санал	2026 төсөвлөл	2027 төсөвлөл	2023 Гүйц	2024 ХБГ	2024 бат	2024 хяз	2025 хяз	2025 сан
<b>80100 Ундсын үйл ажиллагаа</b>													
80101	Ундсын үйл ажиллаганы зардал	5,449,363.60	7,457,172.00	7,457,172.00	14,952,359.10	16,447,595.01	18,092,354.51	73%	100%	73%	100%	50%	50%
2101	210101 Ундсын палин	3,288,558.96	4,679,680.00	4,679,680.00	8,868,354.80	9,755,190.28	10,730,709.31	70%	100%	70%	100%	53%	53%
210102	Нэмэгдэл	973,829.91	1,419,800.00	1,419,800.00	2,586,462.80	2,845,109.08	3,129,619.99	100%	100%	100%	100%	55%	55%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	490,499.28	582,369.00	582,369.00	1,354,056.00	1,489,461.60	1,638,407.76	100%	100%	100%	100%	43%	43%
210104	Ур дунгийн урамшуулал	696,475.45	775,323.00	775,323.00	2,143,485.50	2,357,834.05	2,593,617.46	100%	100%	100%	100%	36%	36%
<b>2102 Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал</b>													
210201	Тэтгэврийн даатгал	692,725.23	932,148.00	932,148.00	1,885,597.60	2,074,157.36	2,281,573.10	74%	100%	74%	100%	49%	49%
210202	Тэтгэмжийн даатгал	459,647.23	633,860.00	633,860.00	1,282,206.40	1,410,427.04	1,551,469.74	100%	100%	100%	100%	49%	49%
210203	УОМШ-ний даатгал	58,269.60	74,572.00	74,572.00	150,847.80	165,932.58	182,525.84	49%	100%	49%	100%	49%	49%
210204	Ажилгүйдлийн даатгал	46,615.60	37,286.00	37,286.00	75,423.90	82,966.29	91,262.92	49%	100%	49%	100%	49%	49%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,654.00	37,286.00	37,286.00	75,423.90	82,966.29	91,262.92	49%	100%	49%	100%	49%	49%
<b>2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>													
210301	Байрны түрээс	116,538.80	149,144.00	149,144.00	301,695.60	331,865.16	365,051.68	100%	100%	100%	100%	77%	77%
<b>2104 Хангамж бараа материалын зардал</b>													
210401	Бичиг хэрэг	72,725.10	71,343.00	71,343.00	92,560.00	101,816.00	111,997.60	102%	100%	102%	100%	77%	77%
210402	Тээвэр шахахуун	31,265.20	24,742.00	24,742.00	37,113.00	40,824.30	44,906.73	126%	100%	126%	100%	67%	67%
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	13,445.20	6,770.00	6,770.00	10,155.00	11,170.50	12,287.55	199%	100%	199%	100%	67%	67%
210404	Ном, хэвлэл	4,165.80	5,558.00	5,558.00	8,337.00	9,170.70	10,087.77	75%	100%	75%	100%	67%	67%
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх	12,580.00	10,379.00	10,379.00	15,569.00	17,125.90	18,838.49	121%	100%	121%	100%	67%	67%
<b>2106 Эд хогшил, урсгал засвар</b>													
1,074.20 2,035.00 2,035.00 3,052.00 3,357.20 3,692.92													
<b>326.90 320.70 320.70 481.00 529.10 582.01 61% 100% 61% 100% 67%</b>													



НИИТ, Эх Үүсвэр 8,963,753.11 14,727,637.00 14,727,637.00 23,193,018.70 25,237,320.57 27,761,052.63

## Г.Хөтөлбөрийн орон тооны мэдээлэл

1.Улс төрийн албан хаагч (УТ)	3.00	3.00	3.00	3.00	3.00
2.Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	11.00	11.00	11.00	8.00
3.Ажлын албаны албан хаагч (АА)	150.00	184.00	184.00	184.00	212.00
<b>Нийт, Орон тоо</b>	<b>160.00</b>	<b>198.00</b>	<b>198.00</b>	<b>198.00</b>	<b>240.00</b>

## ҮНДСЭЛЭЛ, ТАЙЛБАР:

\*Санхүүжилтийн эх үүсвэр, хөтөлбөрийн зардал, зардлын зориулалт болон арга хэмжээ болон байгууллагаар хуваарилсан дүн хоорондоо тэнгэрж байх ёстой.

## Е.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 2024-2026 онуудын гол зорилтууд

## ҮНДСЭН ЗОРИЛГО:

Хорооны зүгээс нэн шаардлагатай салбарын хууль тогтоомжуудыг шинэчлэн боловруулж батлуулах, хууль тогтоомжуудыг даган зохицуулалтын дүрэм, журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, Түүнчлэн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжин, хууль эрх зүйн тавагтай орчныг бүрдүүлж, санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрийг нэмэгдүүлэн салбарын хэмжээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх. ДЭД ЗОРИЛТ 1.1. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗОХИЦУУЛАЛТАЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, ҮҮРЭГ ӨРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ 1.1.1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох

1.1.2. Зах зээлд оролгогч, зохицуулалттай байгууллагуудын өрсөлдөх чадвар, үүрэг оролцоог нэмэгдүүлэх 1.1.3. Цахим технологид суурилсан болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих ДЭД ЗОРИЛТ 1.2. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ЗОРИЛТ 1.2.1. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих, шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээг тогтоох; 1.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ 1.3.1. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах тогтоолоог сайжруулах ДЭД ЗОРИЛТ 1.4 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООЖИГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 1.4.1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт, биелэлтэд нь хяналт тавих 1.4.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих. **Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр** дараах бодлого, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд олон улсын шинэлэлт зохицуулалтыг тусгаж нэмэлт өөрчлөлт оруулах
2. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үндсэн хөшүүрэг болох татварын таатай орчинг бүрдүүлэх
3. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьцааг хөрөнгийн зах зээлээр дамжуулан хувьцахтай холбоотой бүртгүүлэх ажилд дэмжлэг үзүүлэн ажиллах
4. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтоолоог хөгжүүлэх чиглэлээр хувийн тэтгэврийн сан, хамтын нээлттэй, хаалттай хөрөнгө оруулалтын сангуудыг татварын бодлогоор дэмжих
5. Хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр үнэт цаас эзэлдүүлэх, зээлдэх зохицуулалтын орчинг бүрдүүлэх
6. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн тогтоолооны үр ашигт байдлыг дээшлүүлэх чиглэлээр санхүүгийн шинэ технологийн дэвшилгйг ашиглаж, хурдан шуурхай, зуучлагчийн оролцоогүйгээр оролцох, дансаа удирдах, шимтгэл хураамжийг бууруулж үйлдлийн зардал "transacion cost" бууруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх
7. ТӨИ-100 ААН-үүдийг хөрөнгийн зах зээлд ПРО хийх, компанийн бонд гаргахад тавих нөхцөл, шаардлага, цаг хугацаа, өртгийг бууруулж, үнэт цаас гаргах ажиллагааг халбаршуулах
8. Жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хамгаалалтын арга хэрэгсэл, боломжийг зохицуулалтын орчноор бүрдүүлэх
9. Уул уурхайн бүтээгдэхүүн 2024 оноос 100 хувь брөкороор дамжуулагдан уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалагдахтай холбоотойгоор шинээр батлагдсан хууль, журмыг олон нийгэд таниулах, шаардлагатай тохиолдолд журмыг холбогдох зохицуулалтуудыг сайжруулах
10. Дотоодын ногоон хөрөнгө оруулалт, ногоон бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхтэй холбоотой бодлогын арга хэмжээг авч ажиллах, шаардлагатай гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах. **Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд** ФАТФ-аас урьдчилсан байдлаар зарласан дараагийн шатны харилсан үнэлгэний хуваарилар Монгол улсад 2028 онд харилцан үнэлгээ хийхээр тусгасан бөгөөд тус харилцан үнэлгэнд бэлтгэх, Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтоолоог бэхжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны хэмжээнд жил ирэх тусам өргөжин тэлж буй зохицуулалтын салбаруудын онцлогт томирсон бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, салбар тус бүрийн эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, технологид суурилсан хяналт шалгалтын арга техникийг нэвтрүүлэх, Засгийн газраас "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсангай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор "Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030)"-г баталсан. Энэ хүрээнд тус төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилгын хүрээнд 6 томоохон ажлуудыг хэрэгжүүлэх, мөн мэдээлэх үүрэгтэй этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, тохиромжтой этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээдтэй хамсаарал бүхий этгээдтэй хамсааралтай эсэхийг таниж мэдэх, байгууллага тус бүрийн эрсдэлийг үнэлэх, харьцуулах, хяналт шалгалтын нэгдсэн статистик төлөвийг харах боломжтой, хувийн хэргийн мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, шийтгэлийн түүх, зэргийг нэг дорроос харах боломжтой нэгдсэн цогц програм хангамжийг хөгжүүлэх, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.3-т "энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах, хуулиар хүлээн үүргийн хэрэгжилтийг хангуулах" бүрэн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалт, зохицуулалтыг ФАТФ-ын Зөвлөмж, стандартын дагуу үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавихад ашиглагдах олон улсын стандарт, шаардлагыг хангасан блокийн системд суурилсан хяналтын програм хангамжтай болох, МУТСТ чиглэлээр сургалтыг эрчимжүүлэх, гэр дундаа эрсдэлийн үнэлгээний ач холбогдол, үр дагаврын талаар таниулах, Монгол Улсын МУТСТ тогтоолоо, залгамж чанар, ач холбогдлыг ажисан түвшинд нэгдсэн ойлголтод хүрэх зорилготой "Компанаенс форум"-ыг ирэх онд Улсын Их Хурлын даргын ивээл дор тус Хорооны зохицуулалттай 7 салбарын хүрээнд зохион байгуулах.

## Ж. Зардлын тойм-зардлын дүн шинжилгээ

Хорооны 2025 оны төсвийг багтагдсан төсвийн хягаараас нийт 9,279.8 сая төгрөгөөр зайлшгүй нэмэгдүүлэх саналаа хүргүүлж байна. Нийт зардлын 66.7 хувийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 100.5 хувь буюу 7,495.18 сая төгрөг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 102.3 хувь буюу 953.4 сая төгрөг нь ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардал эзэлж байна. Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу төрийн албан хаагчийн албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цол, зэрэг дэв, хоол, унааны хөнгөлөлт, бусад нэмэгдэл хөш, үр дүнтгийн урамшуулал, мөн тус Хорооны хяналт зохицуулалтад хамарах салбарын үйл ажиллагаа хуулиар нэмэгдсэнгэй холбогдуулан шинээр нэмэгдэж байгаа орон тоонд хамаарах цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад нийгмийн баталгааг хангахад зориулах наг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох зардал;

Мөн Засгийн газрын 2024 оны 121 дүгээр тогтоолоор төрийн албаны цалингийн хэмжээг нийгэд нь 10%-иар нэмэгдүүлсэн, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал

олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт орж төрийн жинхэнэ албан хаагчид олгох ажлын үр дүнгээр тооцоо улирлын мөнгөн урамшуулын хэмжээнд өөрчлөлт орсон зэрэг зөрүү, бусад нийгмийн баталгааг хангахад зориулах нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох зардлыг тооцож төлөвлөсөн, 29.7 хувь нь 3294.2 м2 талбайн ашиглалт, үйлчилгээний зардал нэмэгдсэнтэй холбоотой холбоотой эх үүсвэр дутагдаж байгаа байгууллагын дотоод үйл ажиллагааг автоматжуулж, үйлчилгээг түргэн шуурхай болгох, дэд системүүдийг хөгжүүлэх, гамшиггүй үеийн өгөгдлийн бааз сэргээх төв байгуулах, мэдээлэх зардал, 1.3 хувь нь төрийн албан хаагчид өндөр настны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохтой холбоотой зардал, 21.5 хувь нь Засгийн газрын гадаад урсгал шилжүүлгийн зардал болох олон улсын гишүүн байгууллагын төлбөр хураамжийн гадаад валютын ханшийн зөрүүгийн зардлыг тус тус эзэлж байна.

### 3. Төсвийн хязгаараас давсан саналын үндэслэл, тайлбар, нотолгоо

**Хороо хуулиар дүлээх чиг үүргээ биелүүлж үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай 2025 оны төсөвт нэмэгдүүлж сулгах зардлууд:** Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлж, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай дараах зардлуудыг тусгасан болно. Үүнд, **Нэг**. Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоол, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу төрийн албан хаагчдын албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цол, зэрэг дэв, хоол, унааны хөнгөлөлт, өөрсөд нэмэгдэл хөлө, үр дүнийн урамшуулал, мөн тус Хорооны хяналт зохицуулалтад хамаарах салбарын үйл ажиллагаа хуулиар нэмэгдсэн тэй холбогдуулан шинээр нэмэгдүүлэх орон тоонд хамаарч цалин хөлө, нийгмийн даатгалын шимтгэл, бусад нийгмийн баталгааг хангахад зориулах нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох зардал,

**Хоёр**. Засгийн газрын байранд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын эзэмшиж байгаа байр, талбай, авч байгаа үйлчилгээний хэмжээнд нэгдэх байр ашиглалтын зардлыг тухайн байгууллагын төсөвт суулган төлөвлөх, улсын төсвөөс санхүүжүүлж байхад зарсны дагуу тус зардлыг тусгасан ба байр ашиглалттай холбоотой метр квадратын зардал өмнөх оноос нэмэгдсэн тул тус зардлыг нэмэгдүүлсэн,

**Гурав**. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос дээш жил төлсөн, тэтгэвэр тогтоолоо нас хүрсэн, 2025 оны тэтгэвэрт гарах хүсэлтээ өгсөн 2 төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохтой холбоотой зардлыг журмын дагуу тооцож, нэмж тусгасан;

**Дөрөв**. Хорооны үндсэн үйл ажиллагаатай холбоотой эх үүсвэр дутагдаж байгаа эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулиудын шинэчлэлтэй нийцүүлж, хэлэлцүүлж зохион байгуулах зардал, Засгийн газрын гадаад урсгал шилжүүлгийн зардал болох олон улсын гишүүн байгууллагын төлбөр хураамжийн гадаад валютын ханшийн зөрүү, Хорооны гишүүд болон Хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин хөлө, ажлал олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зохицуулалттай зах зээлийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс урьчилан сэргийлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын томилолтын зардлуудыг тус тус нэмж төсөвлөсөн.

**Тав**. Шинээр батлагдсан болон батлагдах хууль тогтоомж, дүрэм, журмыг 2024 оны хэрэгжүүлэхэд тус Хорооны Ажлын албаны бүтэцэд шинээр 2 албыг байгуулах, мөнгөн зээлийн болон уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналтын чиглэлээр нийт 25 орон тоо нэмэгдүүлэх үндэслэл, хэрэгтэй шаардлага тулгарч байна. Үүнд:

а) Мөнгөн зээлийн зохицуулалтын алба (8) орон тоо

Монгол Улсын Их Хурлаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталж, 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээр Санхүүгийн зохицуулах хороо дээрх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус Хороо мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх эгтгээдийн бүртгэлийн асуудлыг харьцах, бодлогоор хангаж, хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сан үүсгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж эхлээд байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх эгтгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам", "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөглөх, тайлан мэдээ яруулах журам", "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх эгтгээдэд хувийн дугаар олгох журам", "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус батлан, мөрдөж байна.

Иймд Мөнгөн зээлийн зохицуулалтын албыг дарга-1, бодлого зохицуулалтын чиглэлийн ахлах референт-1, референт-1, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн ахлах референт-1, референт-1, бодлого зохицуулалтын чиглэлийн ахлах мэргэжилтэн-1, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн мэргэжилтэн-2, нийт 8 орон тоотойгоор ажиллуулах шаардлагатай байна.

б) Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн алба (4) орон тоо

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Дээрх хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулж уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо харуулан ажиллахаар заасан. Дээрх хуулийн хүрээнд "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуулагч/брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа гаргалчид таавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам"-ыг батлаад байна.

"Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргалчид таавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам"-ыг батлаад байна.

Иймд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн албыг дарга-1, бодлого зохицуулалтын чиглэлийн ахлах референт-1, референт-1, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн ахлах мэргэжилтэн-1, нийт 4 орон тоотойгоор ажиллуулах шаардлага бий болсон.

в) Хяналт шалгалт зохицуулалтын газарт мөнгөн зээлийн хяналтын чиглэлээр (5), уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналтын чиглэлээр (4) орон тоо

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хяналт шалгалтын чиг үүргийг ахлах референт-1, ахлах хяналт шалгагч-1, хяналт шалгагч-3, нийт 5 орон тоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналтын чиглэлийн ахлах хяналт шалгагч-1, хяналт шалгагч-3, нийт 4 орон тоотойгоор тус Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын бүтэцэд ажиллуулах шаардлага бий болсон.

г) Санхүүгийн боловсрол, сургалтын алба (4) орон тоо

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.13-д 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр нэмэлт орж "Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах" чиг үүргийг хуулиар хүлээсэн. Санхүүгийн зах зээлийн салбарын өсөлт болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа, технологийн суурилан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, сэндибоксын зохицуулалтын орчин, цаашид мөнгөн зээлийн үйл ажиллагаа буюу ломбард, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа зэрэг батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн боловсролыг олон нийт, хүүхэд залуучуудад хүргэх шаардлага тулгарч байна. Иймд Санхүүгийн боловсрол, сургалтын албанд ахлах референт-1, референт-1, ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн-1 нийт 4 орон тоотойгоор өргөжүүлэх шаардлагатай байна.

Мөн Санхүүгийн хориг хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын 40 Зөвлөмжийн 25 нь тус Хороонд шууд болон шууд бусаар хамаралтай бөгөөд Зөвлөмж 15-ын үнэлгээг "хагаас хэрэгжсэн" гэж 2021 онд үнэлснийг "дийлэнх нь хэрэгжсэн" болгож, 1 шатаар амжилттай ахиулснаар Монгол Улс ФАТФ-ын нийт 40 техник зөвлөмжийн 39 "бүрэн хэрэгжсэн" үнэлгээтэй болж ахиц гаргасан боловч ФАТФ-ын Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АРД/-ээс Монгол Улсыг 2027 оныг дуустал жил болгон явцан тайлан гаргаж тайлагнах үүргийг өгсөнтэй холбоотойгоор Монгол Улсын хувьд 2024 он мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хувьд онцгой жил байх болно.

Үүнтэй холбоотойгоор 2024 онд Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны ээлжит харилцан үнэлгээг хийх бэлтгэл ажлыг хангуулах, үндэсний хөгөлбөрийг хэрэгжүүлэх, тус чиглэлээр үр дүнтэй тогтоолоог бүрдүүлэх, өнөөгийн нөхцөлд хүрсэн төвшинг тогтвортой хадгалах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг эрчимжүүлэх, хянан шалгагчдыг мэргэшүүлэх, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх зэрэг ажлыг зайлшгүй хийх шаардлага тулгарч байна.

Мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдаж, 2022 оны 6 сарын 25-ны өдрөөс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг Хороо бүртгэлжүүлэх үйл ажиллагаа эхэлсэнгэй холбоотойгоор виртуал хөрөнгийн арилжаанд цахим хяналт тавих олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн платформ нэвтрүүлэх виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийг тогтмол үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зайны болон газар дээрх хяналт шалгалтыг эрчимжүүлэх, ФАТФ-ын зөвлөмж 15-д нийцүүлсэн "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ" -ээр тогтоогдсон асуул занаал, мөнгө угаах гэмт хэрэг гарах эрсдэлийг бууруулах чиглэлээр үр дүнтэй ажлыг зохион байгуулах зэрэг зайлшгүй хийгдэх ажлуудын зардлуудыг төлөвлөсөн;

Мөн дээрх хуулиудыг баталсангай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас "Хууль баталсангай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 2021 оны 99 дүгээр тогтоолыг баталсан ба тус тогтоолын 1-д "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, хүний нөөц болон бусад холбогдох зардлыг 2024 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх, шаардлагатай бусад дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /ИОкуун-Эрдэнэ/-г даалгаусгай" гэж заасан.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, тэдгээрийн бүртгэл, үйл ажиллагаатай холбоотой журмуудыг зохицуулалт, хяналт шалгалт хийх, үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах, бүртгэлээс хаах болон технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитгоор туршиж, нэвтрүүлэх сэндибокс зохицуулалтын орчинт бий болгох, холбогдох зохион байгуулалтын нэгж, зөвлөл байгуулах зэрэг харилцааг зохицуулсан Сэндибокс зохицуулалтын журмыг баталж, хяналт тавих чиг үүргүүдийг тус Хороо хэрэгжүүлэхээр болсон.

МАЯГТ НМ-01. ТӨСВИЙН ЕРӨНХИЙ ЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬАЛАХ ТӨСВИЙН БАЙГУУЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГЫН САНАЛ

Нөлөөлөгч хүчин зүйлс						
Дэс дугаар	Үйл ажиллагааны нэр төрөл	2025 оны Төсвийн хязгаар	Нийт өөрчлөлт	2025 оны төсөв		
		9.	8=1+2+3+4+5+6+7	9+8	1.	2. 3. 4. 5. 6. 7.
1	Үйл ажиллагаа 1	2,737,668.00	569,126.00	3,306,794.00		
2	Үйл ажиллагаа 2					
...	...					
<b>Нийт</b>		<b>2,737,668.00</b>	<b>569,126.00</b>	<b>3,306,794.00</b>		569,126.00

Нөлөөлөгч хүчин зүйлс	
1	2
1	УИХ, Засгийн газрын бодлогын шийдвэрээр үнэ, тарифт орсон өөрчлөлт
2	Тогтмол зардлын үнийн өсөлтөөр орох өөрчлөлт
3	Инфляци (зөвхөн Сангийн яам тогтооно)
4	Шинээр бий болох үйлчилгээ, үйл ажиллагаа
5	Бусад макро эдийн засгийн нөлөөгөөр орох өөрчлөлт
6	Үйлчилгээ үзүүлэх хамрах хүрээний өөрчлөлт
7	Ханшийн өөрчлөлт (зөвхөн Сангийн яам тогтооно)

Тайлбар:

1. Төсвийн хязгаар гэж ТЕЗ-дал хүргүүлсэн төсвийн хязгаар болно.
2. Дараа оны төсөв гэж төсвийн төсөл үйлчлэх оны төсөв болно.

ТЕЗИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖИЙН ХАВСРАЛТ

МАЯГТ НМ-02. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГЫН САНАЛЫН ТӨВЧӨӨ

Код	Эдийн засгийн ангиллын зүйлс	2025 оны Төсвийн хэргээр	Нийт өөрчлөлт	2025 оны төсөв	Нөлөөлөгч хүчин зүйлс									
					.12.	11=1+2+3+4+5+6+7+8+9+10	11+12	1.	2.	3.	4.	5.	6.	7.
					УИХ, Засгийн газрын боллогын шийдвэрээр үнэ, тарифт орсон өөрчлөлт	Тогтмол зардалын үнийн өсөлтөөр орох өөрчлөлт	Инфляци /лоохон Сангийн яам тохируулга хийгч/	Хууль, эрх зүйн хүрээний өөрчлөлт	Өмнөх жилийн дундур хэргэж эхэлсэн арга хэмжээний бүтэн жилийн зардал	Шинээр ашиглагдсан орсон өмч хөрөнгийн урсгал зардал	Хөтөлбөр, арга хэмжээнд орсон өөрчлөлт	Бусад макро эдийн засгийн нөлөөгөөр орох өөрчлөлт	Үйлчилгээ үзүүлэх хамрах хүрээ, хүн амын тооны өөрчлөлт	Ханшийн өөрчлөлт (лоохон Сангийн яам тогтооно)
2101	Цалин хөлс болон урамшил	7,457,172.00	7,495,187.10	14,952,359.10				7,495,187.10	0.00	0.00	-	0.00		0.00
2102	Ажил олгогчоос нийгэмийн даатга	932,147.00	953,450.70	1,885,597.70				953,450.70						
2103	Байр ашиглагттай холбоотой тор	71,343.00	21,217.00	92,560.00		21,217.00								0
2104	Хангамж, бараа материалын зар	24,742.00	12,371.00	37,113.00		12,371.00								
2106	Эд хогшил, урсгал зардал	320.70	160.30	481.00		160.30								
2107	Томилголт, зочны зардал	35,556.00	235,765.00	271,321.00				235,765.00						
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн АУТХ	4,859,577.00	214,596.00	5,074,173.00		214,596.00								
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,237.00	1,113.00	2,350.00		1,113.00								
212	Татвас													
213	Урсгал ишжүүлэг	531,042.00	96,022.00	627,064.00				96,022.00						
22	Хөрөнгийн зардал							0						
	Бусад							250,000.00						
	Хөрөнгийн зардал													
<b>Нийт</b>		13,913,156.70	9,279,882.10	23,193,038.80		249,457.30		9,030,424.80						

Нөлөөлөгч хүчин зүйлс	
1	2
УИХ, Засгийн газрын боллогын шийдвэрээр үнэ, тарифт орсон өөрчлөлт	Гарсан шийдвэрүүд
Тогтмол зардалын үнийн өсөлтөөр орох өөрчлөлт	
Инфляци**	
Хууль, эрх зүйн хүрээний өөрчлөлт	
Өмнөх жилийн дундур хэргэж эхэлсэн арга хэмжээний бүтэн жилийн зардал	
Шинээр ашиглагдсан орсон өмч хөрөнгийн урсгал зардал	

ГАРСАН ШИЙДВЭР, ХОЛБОГЛОХ ТАЙЛБАРЫГ АЛБАН ТООТЫН ХАВСРАЛТААР ХҮРГҮҮЛЭВ.

7	Хөтөлбөр, арга хэмжээнд орсон өөрчлөлт
8	Бусад макро эдийн засгийн нөлөөгөөр орох өөрчлөлт

9 Үйлчилгээ үзүүлэх хамрах хүрээ, хүч амын тооны өөрчлөлт

10 Халишийн өөрчлөлт (зөвхөн Сангийн яам тогтооно)

Тайлбар:

1. Төсвийн хэлтсээр гэж ТЭЗ-аад хүрүүлсэн төсвийн хэлтсээр болно. Орон нутгийн төсвийн байгууллагын хувьд 2018 оны төсвийн ХБГ нь тухайн төсвийн жилийн хэлтсээр нь болно.
2. Дараа оны төсөв гэж төсвийн төсөл үйлдэх оны төсөв болно.